

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН ТАНИЛЦУУЛГА



Г.Мөнх-Эрдэнэ

Боловсрол:

Хөрөнгийн зах зээлийн шинжээч Г.Мөнх-Эрдэнэ нь бизнесийн эдийн засагч мэргэжлээр Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн төгссөн. CFA шалгалтын LEVEL2-ийг даваад байгаа.

Оюутан байхаас эхлэн хөрөнгийн зах зээлээр мэргэшиж дөрвөн эрдэм шинжилгээний ажил хэвлүүлэн улсын хэмжээний олон хуралд оролцож эхний байруудад шалгарч байсан. Мөн хөрөнгийн зах зээлийн чиглэлээр гурван номыг санаачлан бичиж, орчуулан олны хүртээл болгоод байгаа нэгэн.

Ажлын туршлага:

2012 онд ажлын гараагаа үнэт цаасны зах зээлээс эхэлж даатгалын салбарт ажиллаж байгаад одоо банкны секторт хүч үзэж байна. Ажиллах хугацаандаа 2016 онд Монгол Шуудан Төрийн Өмчит Хувьцаат Компанийн 34%-ийг олон нийтэд хувьчлах ажлыг гардан гүйцэтгэж 6.2 тэрбум төгрөгийн амжилттай босгосон бол Голомт банкинд ажиллахдаа өөрийн санаачилгаар шинэ алба байгуулан ганцхан жилийн хугацаанд алт арилжааны чиглэлээр Монголын тэргүүлэх банк болгож чадсан.

Өөрийн үндсэн ажлын хажуугаар нийгмийн идэвхитэн Г.Мөнх-Эрдэнэ нь Анд-Энерги ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Монголын хөрөнгийн зах зээлийн судалгаа хөгжлийн нийгэмлэгийн тэргүүний албыг хашдаг. Мөн Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Ёс зүйн хорооны дарга, Хөрөнгө оруулагч үндэстэн ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан.

Ил захидал:

Үнэт цаасны эксперт Г.Мөнх-Эрдэнэ нь арав гаруй жилийн үнэт цаасны арилжааны туршлага, мэргэжлийн компаниудад ажиллахдаа хуримтлуулсан туршлагадаа үндэслэн ТУС-гийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулахад оролцож, хөрөнгө оруулагчдын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллахад бэлэн байна.

